



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/163/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn (Дорноговь аймаг , Сайншанд сум) 2018 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 99092469 Цахим хаяг: Аудитын менежер: Э.Энхцэцэг Утас: 90077079 Цахим хаяг: Аудитор: Г.Энхтөр Утас: 96441690 Цахим хаяг:</p>
--	--

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	(Аудитын чиглэл).....	
3.1.1	Илрүүлэлт:.....	
3.1.2	Эрсдэл:	
3.1.3	Өгсөн зөвлөмж:	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
3.2	(Аудитын чиглэл).....	
3.2.1	Илрүүлэлт:.....	
3.2.2	Эрсдэл:	
3.2.3	Өгсөн зөвлөмж:	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр.
Утас: (705) 2-27-34
2019. 02. 26 № 2-6/208
танай _____ -ны № _____ -г

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ГАЛБА-ӨӨШ, ДОЛООДЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.ЯЛАЛТБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.11-наас 2019.02.13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.29-ны өдрийн ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа нь Сав газрын хэмжээнд усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам нь Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааг 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А-87 тоот тушаалаар байгуулж үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- (Усны менежмент, төлөвлөлт)
- (Усны нөөц, ашиглалт зохицуулах)
- (Мэдээлэл хяналт, шинжилгээ үнэлгээ)
-

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

"Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл"-с хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний гэрээний хугацаа дууссан. Дээрх хугацаанд Австралийн Олоэ улсын хөгжлийн агентлагийн олгож буй буцалтгүй тусламжаар санхүүжүүлэгдэж байсан байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн "Acolous" санхүүгийн программ" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Батлагдсан төсвийн дагуу зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа 2018 оны *Нийт зардал* 441.10 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 441.10 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно..

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	0	0.00	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

“-----”

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

Байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 153188,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 154168,2 мянган төгрөг буюу 100,6 хувьтай байгаа нь төсөв хэтрээгүйгээс шалтгаалжээ.

Байхгүй

2.11 Шилэн дансны мэдээлэл

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Зөвлөмж өгөөгүй байна.

Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймаг дахь Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

“2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/39 тоот тушаалаар хангамжийн материалын бүртгэлд бүртгэсэн 25 нэр төрлийн хангамжийн зүйлсэд 3480000 төгрөгийн үнэ бүхий 3 нэр төрлийн хөрөнгө Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангаж буй тул хөрөнгүүдийн ангиллыг санхүүгийн байдлын тайланд үнэн зөв илэрхийлэх”

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны эхний хагас жилийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,349,050.00	8,231,033.31
35	БАРАА МАТЕРИАЛ	1,349,050.00	8,231,033.31
354	Хангамжийн материал	1,349,050.00	8,231,033.31
35410	Бичиг хэргийн материал	279,000.00	57,000.00
35420	Аж ахуйн материал	500,050.00	7,534,033.31
35440	Түлш, шатах тослох материал	570,000.00	640,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,875,062.50	631,106,800.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,875,062.50	631,106,800.84
392	Биет хөрөнгө	2,875,062.50	627,815,300.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	109,594,854.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-89,571,061.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,149,000.00	960,749,795.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,937.50	-375,708,736.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	51,329,286.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-28,578,837.65
	Бусад үндсэн хөрөнгө	1,750,000.00	
39303	Бусад биет бус хөрөнгө		3,291,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,224,112.50	639,337,834.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,224,112.50	639,337,834.15
51	Засгийн газрын хувь оролцоо	4,224,112.50	639,337,834.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	3,291,500.00
51101	Өмч: - төрийн	00.00	3,291,500.00
512	Хуримтлагдсан үр дүн	4,224,112.50	636,046,334.15
51210	Өмнөх үеийн үр дүн	4,224,112.50	4,224,112.50
51220	Тайлант үеийн үр дүн		631,822,221.65
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4,224,112.50	639,337,834.15



Галба-Өөш долоодын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СТ-2А

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	151,147,874.00	852,371,586.95
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО		693,703,386.95
120	Нийтлэг татварын бүс орлого		693,703,386.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		693,703,386.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		693,703,386.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,147,874.00	158,668,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	139,554,600.00	153,188,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	139,554,600.00	153,188,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,593,274.00	5,480,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,633,274.00	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,960,000.00	980,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	146,923,761.50	220,549,365.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	146,923,761.50	220,549,365.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,612,840.56	210,728,693.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,889,055.93	102,179,513.00
210101	Үндсэн цалин	27,336,535.93	74,617,400.00
210102	Нэмэгдэл		15,813,113.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,325,020.00	11,749,000.00
210105	Гэрээг ажлын хөлс	2,227,500.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,788,791.13	12,559,035.00
210201	Тэтгэврийн даатгал	2,442,232.53	8,406,289.00
210202	Тэтгэмжийн даатгал	344,435.15	1,050,785.00
210203	ҮОМНПО-ний даатгал	261,293.51	827,190.00
210204	Ажилгүйдлийн даатгал	87,598.65	206,798.00
210205	Эрүүл мэндийн даатгал	653,231.29	2,067,973.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,693,700.00	11,400,000.00
210304	Байрны түрээс	9,693,700.00	11,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,767,556.00	11,750,597.00
210401	Бичиг хэрэг	1,960,700.00	840,450.00
210402	Тээвэр, шатахуун	11,383,244.00	8,481,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,345,412.00	1,839,567.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		315,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	78,200.00	273,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,772,300.00	4,078,343.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		777,997.00
210604	Урсгал засвар	2,772,300.00	3,300,346.00
2107	Томилголт, зочны зардал	5,401,500.00	5,880,100.00
210702	Дотоод албан томилголт	5,401,500.00	5,880,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	396,000.00	372,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		240,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	903,937.50	62,509,105.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,937.50	62,509,105.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,310,920.94	9,820,672.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	74,310,920.94	9,820,672.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,310,920.94	9,820,672.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,224,112.50	631,822,221.65
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,224,112.50	631,822,221.65

4417144353
ЕЦА0056 9025707

Галба-Өөш долоодын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СТ-2А

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	151,147,874.00	158,668,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,147,874.00	158,668,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	139,554,600.00	153,188,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	139,554,600.00	153,188,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,593,274.00	5,480,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нооц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,633,274.00	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,960,000.00	980,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	151,147,874.00	158,547,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,147,874.00	158,547,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,836,953.06	148,726,528.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,889,055.93	102,179,513.00
210101	Үндсэн цалин	27,336,535.93	74,617,400.00
210102	Нэмэгдэл		15,813,113.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,325,020.00	11,749,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,227,500.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,788,791.13	12,559,035.00
210201	Тэтгэврийн даатгал	2,442,232.53	8,406,289.00
210202	Тэтгэмжийн даатгал	344,435.15	1,050,785.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	261,293.51	827,190.00
210204	Ажилгүйдлийн даатгал	87,598.65	206,798.00
210205	Эрүүл мэндийн даатгал	653,231.29	2,067,973.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,693,700.00	11,400,000.00
210304	Байрны түрээс	9,693,700.00	11,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,876,606.00	11,313,947.00
210401	Бичиг хэрэг	2,239,700.00	618,450.00
210402	Тээвэр, шатахуун	11,953,244.00	8,522,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,345,412.00	1,843,967.00
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,050.00	155,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	178,200.00	173,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,911,300.00	5,026,333.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,139,000.00	1,696,987.00
210604	Урсгал засвар	2,772,300.00	3,329,346.00
2107	Томилголт, зочны зардал	5,401,500.00	5,875,700.00
210702	Дотоод албан томилголт	5,401,500.00	5,875,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	396,000.00	372,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	396,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	880,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	880,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,310,920.94	9,820,672.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	74,310,920.94	9,820,672.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,310,920.94	9,820,672.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		121,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		121,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		121,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		121,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		121,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-121,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		




СТ-4А

АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
C07	Тайлант үеийн үр дүн		4,224,112.50	4,224,112.50
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		4,224,112.50	4,224,112.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		4,224,112.50	4,224,112.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	3,291,500.00	631,822,221.65	635,113,721.65
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,291,500.00	636,046,334.15	639,337,834.15



Галба-Өөш долоодын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,500,000.00	(4,500,000.00)	-
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	4,500,000.00	(4,500,000.00)	-
4	Бараа, үйлчилгээний зардал	-	4,500,000.00	(4,500,000.00)	-
22	Хангамж, бараа материалын зардал	-	3,348,000.00	(3,348,000.00)	-
23	Бичиг хэрэг	-	48,000.00	(48,000.00)	-
24	Тээвэр (шатахуун)	-	3,300,000.00	(3,300,000.00)	-
39	Томилолт, зочны зардал	-	1,152,000.00	(1,152,000.00)	-
41	Дотоод албан томилолт	-	1,152,000.00	(1,152,000.00)	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,500,000.00	(4,500,000.00)	-
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,500,000.00	(4,500,000.00)	-
123	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нооц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,500,000.00	(4,500,000.00)	-
127	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	10.00	10.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

